

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Бавуу	Дугаар	L166
Оршин суугаа аймаг	Сэлэнгэ аймаг	Оршин суугаа сум	Алтанбулаг
Төрсөн газар		Төрсөн он	
Ажил мэргэжил	Музейн ажилтан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Дөрвөлжин сүм	Сүм хийдийн дугаар	СЭАБ 017
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 22	Ярилцлага авсан хүн	Мөнхнасан



Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын Дөрвөлжин сүм

2007 оны 6-р сарын 22-ны өдөр. Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хотын музейн ажилтан Бавуу гуайтай уулзаад байна.

Асуулт:-Дөрвөлжин сүмийг анх хэдэн онд үүсгэсэн юм бол?

Хариулт:-Дөрвөлжин сүмийг анх 1727 онд орос, манжийн хилийн хэлэлцээр болсон юм. 1732 онд **ашиглалтанд** орсон юм.

**Лувсансамдан** гэж хүн **Лувсансандаг** гэдэг хүн хамба нь байсан. 21 оны үед тийм хүн байсан юм гэнэ лээ. 21 оноос 32 он хүртэл байж байгаад тэгээд алга болсон юм гэнэ лээ. Хурал шүү дээ, хуралддаг л байсан.

Асуулт:-Хэд орчим ламтай байсан юм бол?

Хариулт:-17, 18 лам байсан бололтой дуулддаг юм билээ. Энийг яг тэнд сууж байсан хүн хоёр хүнийг би танина.

**Барайшир** гэж хүн байсан юм. Жамбаа гэж хүн байсан юм.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Асуулт:-Бурхан шүтээн нь ямар байсан юм бол?

Хариулт:- Ямандаг бурхан гэдэг байсан юм. Ямар учиртай юм мэдэхгүй.

Асуулт:-Хийдийг юугаар барьсан байсан юм бол?

Хариулт:-Тоосго бололтой юм билээ.

Данзан гуай 1938 оны 1 сарын 7-ны өдөр баригдаад 63 настай байхдаа цаазлагдсан. Ах дүү хоёулаа явж байсан хүн шүү дээ. Лам хүн.

Асуулт:-Жавхлант сумын Хүйтний голын хурлын тухай?

Хариулт:-Хүйтний гол чинь хоёр ч хуралтай. Хүйтний хурал гэж нэртэй байсан. Доошоо эргээд нэг тийм хавтгай цагаан чулуун юутай бас нэг хийдийн туурь бий.

Асуулт:-**Зодын** хурал хаана байсан бэ?

Хариулт:-**Зодын** хурал чинь наашаа мухар луу байгаа.

Асуулт:-Мухрынх гэдэг нь тэр **зодыг** хэлж байна. Мухар хүйтнийх гэж мухар луугаа Мухар хүйтнийх гэдэг гэж байна.

Тэнд бас жижигхэн геополитикийн юм явагдаж байгаа юм л даа. Нөгөө монголчууд хүрээ тэлээд авлаа шүү дээ. Наад тэр доод Шивээнд чинь сүм байж байгаа, хажууд нь цоохор даавууны үйлдвэр гэж байсан. Цөөхөн хэдхэн байшинтай.

Асуулт:-Тэр багана болохоор зэрэг?

Хариулт:-Тэр багана эртээд би наана Наймаачин хотод хүрээд хоёр улсын хэлэлцээр яасан Наймаачин хотод хүрээ тэлсэн. Бариад эхлэхгүй юу. Тэрнээсээ асар хурдан хийхээс өөр аргагүй байдалд орж байсан.

Хоёр улсын хилийн хооронд зарга шүүдэг ийм заргачийн яам гэж байгуулсан. Заргачийн яам гэдэг нь одоогоор хотын захиргаа байжээ дээ нэг ёсондоо. Орос,монголын хилтэй холбогдсон будлианыг шүүж байдаг. Тэгэхээр Заргачийн яамны байшингийн зураг над ирнэ. Заргачийн яамны хашаа гадуураа хөх тоосгон хашаа байж. Тэр хашааны үүдэн дээр хоёр талдаа 4 талаас нь нийлээд дөрвөлжин хэлбэртэй болоод, голдоо мод суулгаж ирээд хашаа **даамангийн** хөл, тийм 8 ширхэг юу байсан, саяхан болтол байсан. Тийм сийлбэртэй чулуу байсан. Дөрвөлжин сүмийн нэг нь дөрвүүлээ бүтнээрээ байгаа. Зүүн талынх нь нэг нь газар доор хэвтэж байгаа, дутуу цухуйгаад хэвтэж байгаа. Нэг нь **цаад талд** нь чулуун дээр тэр шороон дээр **овоолгоотой**, дараатай байж байгаа. Би ухаж үзээд буцаагаад тавьчихсан. Нэгийг нь тэнд нэг айл байшингийн довжоо хийгээд айл нь дошгирлоо болохгүй нь гээд хаячихсан байгаа. Заргачийн яамны байрны хөл гэж... Тэгсэн нэг чулуу нь алга **болчихоод** олдохгүй байгаад байсан чинь ноднин оршуулгын газар нөгөө чулуу чинь байж байна гэсэн. Ийм янзтай байгаа. Одоо нэг нь олдохгүй байгаа.

1730 онд баригдаад 1930-аад оны эхэн үе хүртэл Дөрвөлжин сүм байж байсан. 1932 оны хавьд 17 сан байсан гэдэг байхаа.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Дэлгэрхаан чинь 9 дэд овоотой, орой дээрээ 1970 оны хавар нэг түймэр гарсан.Тэгээд би тэр түймэрт явалцаж байгаад Дэлгэрхааны орой дээр гарахад сайхан дүнзэн байшинтай, чулуун ширээтэй, томоо чулуун байсан. 70 оноос хойш гараагүй, байдаг юмуу, үгүй юу бүү мэд.

Тэр тахилгын л юу боллохтой. Тахилгаа хийж лам нар тэндээ очиж номоо уншдаг байсан юм болов уу? Овоо тахих үеэр ном уншдаг байсан юм болов уу гэж боддог байсан. Дороо 9 жижиг овоотой, эргэн тойрон.

**Хярааныхан Бөхлөө** уулыг тахидаг байсан байх.

Асуулт:-Хутаг-Өндөр гэж уулыг тахидаг байсан уу?

Хариулт:-Хутаг-Өндөр чинь цөөхөн хүн тахидаг байсан. Буриадууд нь **Бөхлөөгөө** тахиж байсан юм болов уу даа. Буриад, монгол хоёр том аймаг байлаа шүү.

Асуулт:-Ерөөгийн Мэндийн дуганы талаар ярьж өгөхгүй юу?

Хариулт:-Би Мэндийн дуган гэдгийг Цангийн хийдийг хэлж байгаа болов уу гэж бодож байна. Буриадууд Цангаа хийд гэдэг юм. Цангийн хийд гэсэн үг. Ингээд их сонин юм гарч ирнэ, эндээс. 1688 онд Ойрадууд энд дайраад тэгээд энэ Орхон, Сэлэнгийн бэлчирт Ойрадын цэрэгт **Чахундоржийн** дүү тэр хүн их цохигдоод тэгээд Өндөр гэгээн Занабазар тэргүүтэй улсууд бүр **зугатсан** байгаа юм. Зүүн тийшээгээ. Цэцэн хан аймаг руу. Тэгээд **зугатаж** яваад Ерөөгийн халуун рашаан Ичлэхийн гол дээр очиж тэнд халуун рашаанд сууж байж. Энд жил орчим болсон гэж ярьдаг юм. Тэнд байхдаа Бурхан багшийн дүрийг чулуун дээр сийлээд, тэгээд Цангийн хийд гэж хийд байгуулаад тэгээд явсан. Буриадууд голдуу оршин суугч буриадууд нь хамниган буриад голдуу улсууд байсан. Энэ **буриадууд** чинь Цангийн гэж хэлдэггүй **Цангай** гэж хэлдэг, **Цангай** хийд нэртэй.

Асуулт:-**Цангай** гэж горхины нэр үү?

Хариулт:-Тийм. Цана гэдэг горхи байгаа юм. Ерөөгийн халуун рашаанаас ойрхон доо. 5, 6 км газар. Ичлэхийн гол дээр байгаа юм. Ерөөгийн халуун рашаан гэдэг маань Ичлэхийн гол дээр байгаа рашаан шүү дээ. Ингээд Ичлэхийн гол **Ичмийн** гол гэж нийлээд **Хонгийн** гол нэртэй болдог юм. **Хонгийн** гол **Шарлингийн** гол нийлээд Ерөө нэртэй гол гэж. Ерөө гэдгээ ерөнхий утгаар нь Ичлэхийн гол дээр байгаа халуун рашааныг.

Асуулт:- **Арирчгийн** дуган гэж байна уу?

Хариулт:-**Арирчгийн** дуган уу?

Асуулт:-Тийм.

Хариулт:-Тэгвэл наадах чинь Сангийн хийд байх нь. Цаашаа **Хатантын** голын эх рүү. **Хатантын** голын эх рүү бүр цаашаагаа тэнд нэг хийд бий. Ичлэхийн хийд гэж. Ичлэх гэж хэлнэ, Ичлэг гэж хэлнэ, Ачлах гэж янз янзаар хэлнэ. Үндэсний хэл нь Ишлэх юм билээ. Судрын чуулганд Ишлэх гэж бичсэн байдаг юм. Тэр Ишлэхийг Сангийн хийд гэдэг юм. Сангай хийд гэж. Тэрнийг Өндөр гэгээн Занабазарын өөрийнх нь санаачилсан хийд шүү. Энэ Сангай хийд бол. Энэ магадгүй монголын хамгийн ууган хийдүүдийн нэг байж магадгүй. Хархорины дараа **Хамарын** хийдийн **дараахь** байж магадгүй. **Хамарын** хийд чинь хожуу **шүү дээ**, 1923 оны хийд. Үүсгэн байгуулагч нь Өндөр гэгээн юм шүү.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Асуулт:-Мэндийн дуган?

Хариулт:-Мэндийн дуган чинь **Хатантын** голын зүүн хойно хийд байсан юм гэж ярьдаг юм билээ. Би тэрнийг үзээгүй, мэдэхгүй. **Хатантын** гол гэж тэр Ичлэхийн чинь **гол руу** хойшоо орж ирсэн, **Арминжийн** гол руу ... тэнд нэг хийд байгаа. Тэр чинь **хойт агын** буриадууд голдуу байдаг.

Асуулт:-Өндөр гэгээнийг таалал болсны дараа ямар хүн хамба нь байсан бэ?

Хариулт:-Ичлэхийн хийдийг үү? Мэдэхгүй. Олддоггүй юм. Би нэг хүн эрнэ. **Ерөөд** нэг хүн мэдэж магадгүй.

Асуулт:-Юугаар барьсан хийд юм бол? мод юмуу?

Хариулт:-Модоор барьсан хийд.

Асуулт:-Өндөр гэгээнийг байх үед хэд орчим лам хурдаг байсан бэ?

Хариулт:-Ёстой мэдэхгүй юм, хэлэх юм үнэхээр алга. Ямар ч байсан тэнд Өндөр гэгээн жил шахам суухдаа Бурхан багшийн дүрийг чулуун дээр сийлээд, бүх рашааны паянг бичээд тэгээд явахдаа Цангийн хийд гэдгийг байгуулаад сууж байсан хийдээ бас Цангийн хийд гэж нэрлээд тэгээд явсан юм гэнэ лээ.

Асуулт:-Хэдэн оны үед байхгүй болсон юм бол?

Хариулт:-30-аад оны үед байхгүй болсон. 32, 33 он гэхэд Ерөөгийн буриадууд бүрэн дууссан. 1933 онд байдаг байхаа Ерөөгийн Хүдэр. Хүдэр чинь Ерөөгийн нэг салаа салбар шүү дээ. Тэнд 16-гаас дээш насны ганцхан эрэгтэй хүн байсан гэж байгаа. Тэр баригдаад бас. Тэр араас нь хөөж ирж барьсан гэж байгаа юм. Тэгээд чи хэдэн настай вэ? Наана шанд руу орж ирж байгаад асуусан юм. 16-тай гэсэн чинь чамаар яах юм гээд явуулсан. Тэгээд ерөөсөө бүхэлд нь Цагаан нуур, Ерөө, Баруунбүрэн энэ 3 чинь хамгийн их өртөгдсөн улсууд байдаг юм. Энд гэр хурал гэдэг, Зэлтэрт гэр хуралтай байсан. Зэлтэрийг ярих бол харин энд байхгүй юм байна лээ шүү. Зэлтэрт Сумъяа бэйсийн дэргэд гэр хуралтай байсан юм гэнэ лээ. Нэр усыг нь тэнд бичсэн байсан, мартжээ, харж байгаад ярихгүй бол мартчихаж. Зэлтэрийн гэр хурал байсан юм.

Асуулт:-Одоо бол тэр Сэлэнгэ аймгийн ямар сумын нутагт байсан юм бэ?

Хариулт:-Тэшиг сумын нутагт.